

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>1-6</i>

1. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	1-6
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 05 дугаар
сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт;

Чөлөөтэй: Ш.Адьяа, Б.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр.

Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Б.Пүрэвдагва, Ёс зүйн хорооны гишүүн М.Цэрэнбат, мөн хорооны Ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга З.Цэдэнжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт С.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн талаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Б.Баттөмөр: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны дарга Б.Баттөмөр үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 12 минут үргэлжилж, 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
14 цаг 45 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баттөмөр: Өнөөдөр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирц бол Баагаагийн Баттөмөр байна. Баделхан гишүүн байна. Баярсайхан гишүүн байна. Бейсен гишүүн байна. Энхболд гишүүн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн байна. Ирц 60 хувийн ирцтэй хуралдаан нээснийг мэдэгдье.

Энэ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороо 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/47 тоот албан бичгээр Сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний 04 дүгээр тогтоолоор баталсан Ёс зүйн хорооны дүрэмд өөрчлөлт оруулахаар санал боловсруулж ирүүлсэн.

Ингээд Байнгын хорооны тогтоолд хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах тухай өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Энд одоо Амартөгс Ёс зүйн байнгын хорооны Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Цэдэвсүрэн байна. Цэдэвсүрэн байна. Баатарсайхан Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Идэрчулуун Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн,

Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Цэрэнбат Ёс зүйн хорооны гишүүн, Цэдэнжав Ёс зүйн хорооны ажлын албаны Захиргаа эрх зүйн хэлтсийн дарга.

Өөр зарлагдаагүй хүн байна уу? Байхгүй байгаа биз дээ. Тийм ээ. Ийм бүрэлдэхүүнтэй ирсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Байнгын хорооны тогтоолын төсөлд хавсралт оруулах тухай тогтоолын танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Амартөгс хийнэ. Амартөгс гишүүн 2 дугаар микрофон өгье.

Ц.Амартөгс: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 23 онд батлан хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчлийн шалтгааныг судлан дүгнэх, дүн шинжилгээ хийх, ёс зүйн зөрчлийн бүртгэл хийж олон нийтэд мэдээлэх, хяналт тавих зорилгоор цахим систем хөгжүүлэх, хуулиар харьяалуулсан албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх зэрэг чиг үүргийг Ёс зүйн хороо хүлээн ажиллаж байна.

Ёс зүйн хороо хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн, Байнгын хорооноос томилогдсон орон тооны бус 4 гишүүн, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газар төрийн болон нутгийн удирдлагын байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын ажиллах журмыг Хууль тогтоомжийн тухай хуульд

нийцүүлэн баталж, ХЗДХЯ-ны бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлж байна.

Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан бүх түвшиний төрийн байгууллагууд, төрийн албан хаагчид олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулан санал авч тусган Баттөмөр даргын ахалсан ажлын хэсгийн зүгээс өгсөн санал зөвлөмжийг тусгаж, хөтөлбөр маань Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан.

Ёс зүйн хорооны дарга, гишүүд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сурталчилгаа мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг 21 аймагт 3-5 дугаар сарын хугацаанд зохион байгуулж, нийт 14392 албан хаагчид ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмж өгч, сургалт зөвлөгөө зохион байгуулж ажиллалаа.

Мөн төрийн захиргааны төв байгууллагууд, салбаруудын хэмжээнд 2 удаагийн сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгсөн, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Пүрэв гаргийн 7:4:10 сургалтаар нийт 2548 байгууллага хэрэглэгчийн эрхтэйгээр оролцсон сургалтад Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэх зөвлөмж, анхаарах асуудлуудын талаар мэдээллийг өгсөн.

Ингээд төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, нийслэл, захирагчийн алба, Улсын Их Хурлын харьяа байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт болон хорооны сургалтын төлөвлөгөөний дагуу цаашид энэхүү сургалт зөвлөгөө өгөх үйл ажиллагааг өргөжүүлэн системтэйгээр зохион байгуулахаар төлөвлөж ажиллаж байна.

Ёс зүйн хороо үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд мөрдөж буй дүрэм, журам, зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага

үүссэн. Энэ хүрээнд бид судлаад Байнгын хорооны 2023 оны 4 дүгээр тогтоолоор баталсан үйл ажиллагааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн Ёс зүйн хорооны үйл ажиллагааны бодлого тодорхойлж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мөн төрийн албаны шинэтгэлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх зорилгоор стратеги төлөвлөгөөг баталж, түүнд нийцүүлэн жил бүрийн төлөвлөгөө гаргаж ажиллах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог илүү нэмэгдүүлэх, сургалт, судалгаа шинжилгээний байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хорооны хуралдаанаар төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргахаас гадна хууль тогтоомжийн хүрээнд олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Хороо, тогтоол, албан даалгавар, зөвлөмж гаргах бол зохицуулалтыг нэмэх, хорооны гишүүдийн бие даан хараат бусаар ажиллах нөхцөл, аюулгүй байдал, цалин хөлс, нийгмийн баталгаатай холбогдох зохицуулалтыг дүрмийн заалтуудад тодотгон оруулах, улмаар цалин урамшууллыг төсөвтөө тусган шийдвэрлэж байгаа байх асуудал, ёс зүйн талаар гаргасан албан хаагчдын ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхэд хяналт тавих бүрэн эрхийнхээ хүрээнд цахим мэдээллийн санг хөгжүүлэх, хяналт тавих, мөн олон нийтэд мэдээлэх асуудлаар Ёс зүйн хороо цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх ийм боломж нөхцөлүүдийг судалж үзээд, Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулж байна.

Энэхүү тогтоолын төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлт нь бусад хууль

тогтоомжтой нийцэж байгаа болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Б.Баттөмөр: Энэ асуудал бол яах вэ. Эхлээд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг ингээд бид нар баталсан. Тэгээд дэд хороод байгуулах ёстой байх, хороо байгуулсан.

Тэгээд дараа нь энэ төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр батлагдсан. Үүнтэй холбогдуулаад энэ тогтоолд бол бас өөрчлөлт оруулах ийм шаардлага байгаа гэж ингэж манай Төрийн албаны зөвлөл Ёс зүйн хорооноос ингэж одоо асуудал тавиад орж ирж байгаа юм.

Тэгээд би бол найруулгын шинж чанартай, тэгээд хэд хэдэн асуудлуудыг шийдэх шаардлагатай гэж ингэж үзээд ингэж байгаа юм.

Асуулт асуух гишүүд байна уу? Тараачихсан байгаа. Энх-Амгалан гишүүн. Байхгүй юу.

Энхболд гишүүн.

Н.Энхболд: Тэгээд би асуултгүй. Би зүгээр ганцхан юу хэлэх гэсэн юм. Төрийн байгуулалтын байнгын хороогоор бас нэг цалин хөлстэй холбоотой асуудал явж байгаа. Удирдлагын түвшинд яриад, хэлэлцэх асуудлын жагсаалтад ороод, ерөнхийдөө бид нар түрүүчийн 7 хоногоос эхлээд хэлэлцье гэж бодсон чинь бас бусад Улсын Их Хурлын харьяанд шууд харьяалагддаг байгууллагууд дээр ийм асуудал байна уу, судалж үзээд байвал нэгмөсөн оруулъя гэсэн ийм чиглэл өгсөн учраас үндсэндээ яваад үзсэн.

Тэгээд бараг өөр газар байхгүй юм шиг байна лээ. Тэгэхээр дараагийн 7 хоногийн хуралдаанаар бид нар тэр асуудлаа оруулаад ямар ч байсан Их Хуралд оруулаад энэ чуулган хаагдахаас өмнө болчих байх гэж бодож байгаа.

Ажлын төлөвлөгөө энэ тэр юманд орчихсон юм. Тэгээд энд ч гэсэн зарим тэр цалин хөлс бусад юмтай холбоотой асуудлуудууд байна.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл Ёс зүйн хороог бол Төрийн байгуулалтын байнгын хороо Ёс зүйн байнгын хорооны зүгээс эрчимтэй дэмжиж, бүх хууль тогтоомж, юмнуудыг гаргаж өг, ажлын зохион байгуулалтад оруулаад ингээд энэ Их Хурлын зүгээс Төрийн албаны зөвлөлийн ажлыг шинэ шатад гаргах, ёс зүйтэй болгох, Ёс зүйн хороотой болгох гэх мэтчилэн томоохон ажлуудыг хийсэн шүү гэдгийг бас энэ хурал дээр зориуд тэмдэглэж хэлчихье гэж бодсон юм. Тийм.

Б.Баттөмөр: Энх-Амгалан сайд үг хэлэх гээд байна уу, үгүй юу.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд асуултаа асууж дууслаа.

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Хэлчихсэн. Үг хэлж дууслаа.

Санал хураалт. Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний 4 дүгээр тогтоолоор баталсан Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийг тараачихсан байгаа. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт.

Тогтоолын төсөл 66,7 хувийн саналаар дэмжигдэж байна.

Ингээ 66,7 хувиар саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ёс зүйн сахилга хариуцлагын “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Байнгын хорооны тогтоолын үг хэллэг, найруулгыг Байнгын хорооны ажлын албатай хамтарч үүнийг дахиж сайн үзээрэй. Найруулгын юмнуудаа үзээрэй.

Ингээд Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Бейсен гишүүн, Энхболд гишүүн, Энх-Амгалан гишүүддээ баярлалаа,

Хуралдаан дууслаа.

Та бүгдэд ч гэсэн надад баярлалаа.

Ажлаа сайн хийцгээгээрэй. Монгол Улс сая Энхболд гишүүн ярилаа. Монгол Улсын Их Хурал энэ ёс зүй гэдэг юмыг бол анх удаа ер нь мартагдсан байсан үг шүү. Үүнийг бол анх удаа гаргаж ирж тавиад ингээд энэ 3 ч хуультай, тогтоолтой болчихлоо шүү дээ, тийм ээ.

Анхных нь бол Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрэм гэж баталсан. Хоёрхон сахилга хариуцлагын хууль, 3 дахь нь соён гэгээрүүлэх. Ер нь бол цаашидаа бол Монгол Улсын хэмжээнд энэ соён гэгээрүүлэх хөтөлбөр, бодлого гэдэг юм Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ дээр та бүгд одоо бас тодорхой хугацаанд шинэ парламентын энэ асуудлыг авч хэлэлцэнэ. Энд та бүгд идэвхтэй оролцоорой.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ